ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/25/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2022 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br><br>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа<br>Утас:92038288<br>Цахим хаяг:zayag@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Б.Дагвасүрэн<br>Утас:99014227<br>Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....................................................... **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................... 4

3. Аудитын тайлан ....................................................... 10

3.1 Ерөнхий зүйл ....................................................... 10

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................................................... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................................................... 11

3.4 Материаллаг байдал ....................................................... 11

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................................................... 11

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....................................................... 11

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....................................................... 13

3.8 Аудитын гол асуудал ....................................................... 13

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................................... 13

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................................................... 13

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................................................... 13

4. Аудитын илрүүлэлт ....................................................... 13

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................... 15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.25. № 370.

танай______________-ны №________________-т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Г.АМГАЛАН -д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

| SORT_ID | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 38,186.2 | 51,873.3 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 0.0 | 0.0 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 0.0 | 0.0 |
| 16 | Гадаад валютаар | 0.0 | 0.0 |
| 17 | Төрийн сангийн харилцах | 0.0 | 0.0 |
| 33 | АВЛАГА | 0.0 | 0.0 |
| 33100 | Хувь хүмүүсээс авах авлага | 500.0 | 500.0 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 0.0 | 0.0 |
| 61 | Түүхий эд материал | 0.0 | 0.0 |
| 63 | Эм боох материал | 0.0 | 0.0 |
| 66 | Хангамжийн материал | 0.0 | 0.0 |
| 67 | Бичиг хэргийн материал | 275.0 | 1,757.9 |
| 70 | Аж ахуйн материал | 2,543.6 | 2,627.9 |
| 71 | Барилгын засварын материал | 0.0 | 0.0 |
| 72 | Хүнсний материал | 0.0 | 0.0 |
| 73 | Бусад хангамжийн материал | 34,867.6 | 46,897.5 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,487,418.8 | 1,366,731.8 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,487,418.8 | 1,366,731.8 |
| 108 | Биет хөрөнгө | 1,220,419.2 | 1,100,259.3 |
| 109 | Барилга, байгууламж | 1,026,774.3 | 1,049,405.9 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | -91360.49 | -135402.60 |
| 111 | Авто-тээврийн хэрэгсэл | 259304.80 | 150304.80 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | -86263.68 | -96815.65 |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 93,070.1 | 87,124.6 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | -52418.91 | -31845.76 |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,948.0 | 48,224.9 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | -30665.30 | 34251.01 |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 204,141.0 | 230,941.0 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | -148110.74 | -167426.84 |
| 126 | Биет бус хөрөнгө | 266,999.6 | 266,472.5 |
| 127 | Програм хангамж | 3,302.0 | 3,302.0 |
| 128 | Хасагдуулга | -1537.42 | -2064.50 |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 265,235.0 | 265,235.0 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,525,604.9 | 1,418,515.1 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 363.0 | 0.0 |
| 139 | Богино хугацаат өглөг | 363.0 | 0.0 |
| 140 | Хаоат-ын өглөг | 363.0 | 0.0 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 1,525,242.0 | 1,418,515.1 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 1,525,242.0 | 1,418,515.1 |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 0.0 | 0.0 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 493,005.8 | 493,005.8 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 939,106.9 | 832,124.6 |

| | | | |
|---|---|---|---|
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 882,594.4 | 938,851.5 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | 56,512.6 | -106,726.9 |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 93,129.3 | 93,384.7 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 1,525,604.9 | 1,418,515.1 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/

| SORT_ID | ITEM_NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 734,054.4 | 942,738.8 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 160,963.6 | 286,279.5 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 156,963.6 | 208,214.5 |
| 81 | Торгуулийн орлого | 0.0 | 24,829.9 |
| | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 0.0 | 5.0 |
| | Туслах үйл ажиллагааны орлого | 0.0 | 5.0 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 155,205.5 | 55,840.8 |
| 87 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал | 1,758.1 | 127,538.8 |
| 88 | Тусламжийн орлого | 4,000.0 | 78,065.0 |
| 92 | Хандив тусламж-дотоод | 4,000.0 | 78,065.0 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 573,090.8 | 573,090.8 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 573,090.8 | 602,501.5 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 573,090.8 | 602,501.5 |
| 122 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.0 | 53,957.9 |
| 127 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 0.0 | 53,957.9 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 664,477.7 | 839,023.6 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 664,477.7 | 839,023.6 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 660,490.8 | 727,520.7 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 265,857.3 | 258,865.7 |
| 151 | Цалин | 246,229.6 | 241,000.8 |
| 152 | Нэмэгдэл цалин | 19,627.7 | 17,864.9 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,234.2 | 35,234.2 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 24,794.4 | 24,794.4 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,609.9 | 2,609.9 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,087.9 | 2,087.9 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 522.0 | 522.0 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 5,220.0 | 5,220.0 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,454.5 | 43,594.4 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 3,243.7 | 4,525.0 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 33,210.8 | 39,069.4 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 40,072.3 | 54,872.6 |
| 171 | Бичиг хэргийн материал | 5,768.7 | 6,101.2 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 27,722.1 | 43,491.7 |
| 173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 6,438.5 | 5,276.7 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 0.0 | 3.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 181 | Бараа материал акталсан зардал | 143.0 | 0.0 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,249.6 | 26,373.8 |
| 189 | Урсгал засвар | 4,249.6 | 26,373.8 |
| 190 | Томилолт зочны зардал | 3,480.0 | 2,930.0 |
| 191 | Дотоод томилолтын зардал | 3,480.0 | 2,930.0 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 144,452.2 | 85,393.9 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,046.0 | 84,052.9 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 188.0 | 232.1 |
| 200 | Даатгалын үйлчилгээ | 469.1 | 469.1 |
| 209 | Тээврийн хэрэгслийн татвар | 227.7 | 227.7 |
| 211 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 29.7 | 73.8 |
| 212 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 353.4 | 200.0 |
| 213 | Газрын төлбөр | 138.3 | 138.3 |
| 214 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130,690.8 | 220,256.2 |
| 215 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,728.9 | 113,522.6 |
| 216 | | 303.4 | 0.0 |
| 218 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 88,658.5 | 106,733.6 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,986.9 | 111,502.9 |
| 228 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,шилжүүлэг | 3,986.9 | 111,502.9 |
| 235 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,986.9 | 111,502.9 |
| 247 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 69,576.7 | 103,715.2 |
| 250 | Үйл ажиллагааны бус зардлын дүн | 13,064.1 | 210,442.0 |
| 251 | Үйл ажиллагааны бус зардал | 13,064.1 | 210,442.0 |
| 252 | Үндсэн хөрөнгө худалдсны гарз | 13,064.1 | 93,675.6 |
| 253 | Үнэ төлбөргүй гарсан зардал-бараа материал | 0.0 | 116,766.4 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 56,512.6 | -106,726.9 |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 0.0 | 0.0 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагд сан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 385,429.76 | 82,199.22 | 878,112.23 | 13,45,741.21 |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 4482.13 | 4482.13 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 385,429.76 | 82,199.22 | 882,594.35 | 1,350,223.33 |
| 5 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 0.00 | 10930.05 | 0.00 | 10930.05 |
| 6 | Үндсэн хөрөнгийн өсөлт | 107,576.00 | 0.00 | 0.00 | 107,576.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бууралт | | | | |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 56512.59 | 0.00 |
| | Зарласан ноогдол ашиг | 493,005.76 | 93,129.27 | 939,106.95 | 1,525,241.98 |
| 10 | 2021 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл | 493,005.76 | 93,129.27 | 939,106.95 | 1,525,241.98 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -255.41 | -255.41 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 493,005.76 | 93,129.27 | 938,851.53 | 1,524,986.56 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 255.41 | 0.00 | 255.41 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0.00 | 0.00 | -106726.89 | -106726.89 |
| 18 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 493,005,760.00 | 93,384,682.13 | 832,124,639.38 | 1,418,515,081.51 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ | ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 577,090.79 | 759,359.17 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,000.00 | 102,899.86 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | - | 24,834.86 |
| 92 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 5.00 |
| 103 | Тусламжийн орлого | 4,000.00 | 78,065.00 |
| 104 | Хандив тусламж-дотоод | 4,000.00 | 78,065.00 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 573,090.79 | 656,459.31 |
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 573,090.79 | 602,501.45 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 573,090.79 | 602,501.45 |
| 113 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 53,957.86 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 574,920.79 | 735,477.67 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 574,920.79 | 735,477.67 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 570,933.87 | 623,974.73 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 265,494.30 | 259,228.68 |
| 151 | Үндсэн цалин | 245,866.60 | 241,363.79 |
| 152 | Нэмэгдэл | 19,627.70 | 17,864.90 |
| 157 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 35,234.20 | 35,234.20 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 24,794.40 | 24,794.40 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,609.90 | 2,609.90 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,087.90 | 2,087.90 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 522.00 | 522.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 5,220.00 | 5,220.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 36,454.48 | 43,594.37 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 3,243.68 | 4,524.97 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 33,210.80 | 39,069.40 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | - | - |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 40,179.29 | 39,400.25 |
| 171 | Бичиг хэрэг | 6,018.70 | 7,191.70 |
| 172 | Тээвэр, шатахуун | 27,722.07 | 26,931.90 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,438.53 | 5,276.65 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,249.60 | 26,531.55 |
| 186 | Урсгал засвар | 4,249.60 | 26,531.55 |
| 187 | Томилолт, зочны зардал | 3,480.00 | 2,930.00 |
| 188 | Дотоод албан томилолт | 3,480.00 | 2,930.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 144,452.20 | 88,273.31 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 143,046.03 | 86,932.31 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 187.98 | 232.10 |
| 200 | Даатгалын үйлчилгээ | 469.10 | 469.10 |
| 201 | Тээврийн хэрэгслийн татвар | 227.70 | 227.70 |
| 202 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 29.68 | 73.80 |
| 203 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 353.40 | 200.00 |
| 204 | Газрын төлбөр | 138.30 | 138.30 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,389.81 | 128,782.37 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,086.41 | 128,478.97 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 303.40 | 303.40 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,986.92 | 111,502.93 |
| 225 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт | 3,986.92 | 111,502.93 |
| 247 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,986.92 | 111,502.93 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 2,170.00 | 23,881.50 |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 2,170.00 | 23,881.50 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,170.00 | 23,881.50 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 2,170.00 | 23,881.50 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,170.00 | 23,881.50 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (2,170.00) | (23,881.50) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 0.0 | (0.0) |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 595,225.6 | 514,124.3 | 26.2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 595,225. | 514,124.3 | (513.5) |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 595.2 | 514,124.3 | (513.5) |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 260,994.3 | 259,228.7 | 1.8 |
| 6 | Үндсэн цалин | 241,366.6 | 241,363.8 | 0.0 |
| 7 | Нэмэгдэл | 19,627.7 | 17,864.9 | 1.8 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,234.2 | 35,234.2 | 0.0 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 24,794.4 | 24,794.4 | 0.0 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 2,609.9 | 2,609.9 | 0.0 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 2,087.9 | 2,087.9 | 0.0 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 522.0 | 522.0 | 0.0 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 5,220.0 | 5,220.0 | 0.0 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 44,568.5 | 43,594.4 | 1.0 |
| 18 | Гэрэл цахилгаан | 2,168.5 | 4,525.0 | (2.4) |
| 19 | Түлш, халаалт | 42,400.0 | 39,069.4 | 3.3 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 38,226.8 | 36,985.3 | 1.2 |
| 23 | Бичиг хэрэг | 6,411.7 | 7,191.7 | (0.8) |
| 24 | Тээвэр (шатахуун) | 24,227.2 | 24,516.9 | (0.3) |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 7,587.9 | 5,276.7 | 2.3 |
| 39 | Томилолт, зочны зардал | 8,414.0 | 2,930.0 | 5.5 |
| 41 | Эд хогшил худалдан авах | 8,414.0 | 2,930.0 | 5.5 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 82,560.1 | 82,541.0 | 0.0 |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 232.1 | 232.1 | 0.0 |
| 46 | Даатгалын үйлчилгээ | 469.1 | 469.1 | 0.0 |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | 227.7 | 227.7 | 0.0 |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73.8 | 73.8 | 0.0 |
| 49 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 203.4 | 200.0 | 0.0 |
| 50 | Газрын төлбөр | 138.3 | 138.3 | 0.0 |
| 51 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15.7 | 0.0 | 0.0 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,000.0 | 27,079.3 | 25.9 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303.4 | 303.4 | 0.0 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.0 | 0.0 | 0.0 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 595,225.6 | 569,001.5 | 26.2 |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 25.00 | 25.00 | 0.0 |
| 134 | Удирдах ажилтан | 10.00 | 10.00 | 0.0 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 8.00 | 8.00 | 0.0 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | 0.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 0.0 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 190,357.7 | 133,731.9 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 190,357.7 | 133,731.9 |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 133,731.9 | 133,731.9 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 2,415.0 | 2,415.0 |
| 23 | Тээвэр шатахуун | 2,415.0 | 2,415.0 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 0.0 | 0.0 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 16,706.6 | 16,706.6 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,706.6 | 16,706.6 |
| 45 | Бараа үйлчилгээний бусад зардал | 114,610.3 | 114,610.3 |
| 46 | Бараа үйлчилгээний бусад зардал | 114,610.3 | 114,610.3 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 190,357.7 | 190,357.7 |
| 120 | Татварын бус орлого | 102,899.9 | 102,899.9 |
| 121 | Нийтлэг татварын бус орлого | 24,834.9 | 24,834.9 |
| 122 | Торгуулийн орлого | 24,829.9 | 24,829.9 |
| 123 | Туслах үйл ажиллагааны орлого | 5.0 | 5.0 |
| 124 | Тусламжийн орлого | 78,065.0 | 78,065.0 |
| 124.1 | Хандив тусламж-дотоод | 78,065.0 | 78,065.0 |
| 125 | Тусламж санхүүжилтийн орлого | 87,457.9 | 87,457.9 |
| 125.1 | Улсын төсвөөс | 33,500.0 | 33,500.0 |
| 125.2 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 33,500.0 | 33,500.0 |
| 125.3 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 53,957.9 | 53,957.9 |
| 126 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгаглсан төсвөөс | 53,957.9 | 53,957.9 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 0.0 |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 0.0 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тосонцэнгэл сумын ЗДТГ нь иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг дээдлэн төрийн үйлчилгээг хууль тогтоомжын хүрээнд эрх тэгш,хүнд сурталгүй ,ил тод ,шуурхай хүргэж сум орон нутгийнхаа хөгжил дэвшилд манлайлагч ,мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны байгууллага болон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 595,3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11,9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (60-80 хувиар) буюу 5.05 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 500.0 | 500.0 | |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 37686.2 | 51283.3 | 13597.1 |
| Үндсэн хөрөнгө | 1487418.7 | 1366731.8 | 120686.9 |
| **Нийт хөрөнгө** | 1525604.9 | 1418515.1 | 107089.8 |
| Өр төлбөр | | 0.0 | 0.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1525604.9 | 1418515.1 | 107089.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1525604.9 | 1418515.1 | 107089.8 |

Бараа материалын дансны үлдэгдэл 13,597.1 мянган төгрөгөөр өссөн нь ковидын хандивын материалын орлого болон сумын өвс тэжээлийн нөөц орлогод авсанаас өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 120,686.9 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын тогтоолоор балансаас балансад хөрөнгө шилжүүлсэн болон акталсантай холбоотой.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 595,225.6 мянган төгрөгөөр, 595,225.6 мянган төгрөгөөр нийт зарлагыг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 569,001.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 514,124.3 мянган төгрөгийг зарцуулж, 54,877.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ковид-19 цар тахалтай холбоотойгоор нутгийн иргэдийн хандиваар 78,065.0 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 53,957.8 мянган төгрөгийн, хүү торгуулийн орлогоор 24,834.8 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоор 5.0 мянган төгрөгийн, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 33,500.0 мянган төгрөгийн, нийт 190,357.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Нэмэлт орлогоос бараа үйлчилгээний зардалд 114,610.3 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 16,706.6 мянган төгрөгийг, тээвэр шатахуунд 2,415.0 мянган төгрөгийг тус тус зарцуулан 56,625.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Иргэдийн хандиваар 127,538.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн материалыг хандивын орлогод хүлээн авч сумын онцгой комиссын шийдвэрээр зарцуулсан бөгөөд үлдэгдлийг тоолон тооллогын бүртгэлд тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Албан томилолтоор ажилласан албан хаагчдын байр хоолны үнэнд 571.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн, Мал тооллогын зардлын 300.0 мянган төгрөгөөр тэмцээн зохион байгуулсан,Ойн хишиг ХХК-д хоол, буудлын үнэнд 402.0 мянган төгрөгийг төлсөн, “Тэр бум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд “Агь наран булаг хангай “ ХХК-аас 4,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан 1200 ш модны зарцуулалтыг нотлох баримт хангалтгүй, хийсэн ажлыг зурагжуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулхаас 6 мэдээлэл хугацаа хожимдуулж 141 мэдээллийг бүрэн оруулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд ковид-19 цар тахлын улмаас тус суманд өндөржүүлсэн хатуу хөл хорионд сар болсноос Улаантолгойн цагдаагийн постонд 12,313.2 төгрөгийн засварын зардал гаргасан боловч нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй, хийсэн ажлыг зурагжуулаагүй байгааг дараагийн аудитаар шалгах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Албан томилолтоор ажилласан албан хаагчдын байр хоолны үнэнд 571.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн, мал тооллогын зардлын 300.0 мянган төгрөгөөр тэмцээн зохион байгуулсан,Ойн хишиг ХХК-д хоол буудлын үнэнд 402.0 мянган төгрөгийг төлсөн, Тэр бум мод тарих хөтөлбөрийн хүрээнд тарьсан 4000.0 мянган төгрөгийн өртөгтэй

модны зарцуулалтын нотлох баримт хангалтгүй, хийсэн ажлыг зурагжуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

**4.1 Залруулсан алдаа: гараагүй**

**4.2 Төлбөрийн акт**

Албан томилолтоор ажилласан албан хаагчдын байр хоолны үнэнд 571.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн, Мал тооллогын зардлын 300.0 мянган төгрөгөөр тэмцээн зохион байгуулсан,Ойн хишиг ХХК-д хоол буудлын үнэнд  402.0 мянган төгрөгийн нийт 1,273.0 мянган төгрөгөнд  төлбөрийн акт тогтоов

**4.3 Албан шаардлага: хүргүүлээгүй**

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай  холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

✓ *“Тэр бум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд “Агь наран булаг хангай “ ХХК-аас 4,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан  1200 ш модны зарцуулалтыг нотлох баримт хангалтгүй, хийсэн ажлыг зурагжуулж баталгаажуулаагүй;*

*Өгсөн зөвлөмж:*

✓ *1200 ш модыг хуваарилсан байгууллагуудын тоо, хийсэн ажлыг баримтаар нотолгоожуулан, тарьсан модны тоог гарган анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд  ирүүлэх;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06  дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Тсоонцэнгэл сумын ЗДТГ | 2 | 5.3 | | | 1 | 1.3 | | | 1 | 4.0 |